



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/463

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг дарга нарын 2019 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.2.4, 3.2.5 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уянга сумын Эрүүл мэндийн төв, Есөнзүйл сумын сум дундын эмнэлгийн эмчийн байр, Уянга сумын Эрүүл мэндийн төвийн амбулаторийн хэсгийн сантехникийн засвар, Тарагт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга сумдын Эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн мэдээлэл боловсруулах зөөврийн компьютер, вакцины хөргөгч, вакцин устгалтын автоклав зэрэг тоног төхөөрөмжөөр хангах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардал 49.833.400 (дөчин есөн сая найман зуун гучин гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, тоног төхөөрөмж зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг Даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100730